

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/90-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II бар
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.25 № 007-2023/90-НАСТАТУС
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НЭГДСЭН
МУЗЕЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.БАЯРБААТАР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилт 96.3 хувьтай төвлөрч, төсвийн гүйцэтгэл 90.9 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 9.1 хувиар хэмнэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 5,000.0 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 63.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн, 11.9 хувийг эд хогшил, урсгал засварын, 9.8 хувийг тогтмол, 10.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал тус тус эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,341,120.00	53,223,133.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	14,343,733.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	14,343,733.00
31210	Төгрөг	0.00	14,343,733.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	14,343,733.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,341,120.00	38,879,400.00
35400	Хангамжийн материал	38,341,120.00	38,879,400.00
35410	Бичиг хэргийн материал	3,172,120.00	1,473,900.00
35420	Аж ахуйн материал	34,825,800.00	37,062,300.00
35450	Барилгын засварын материал	343,200.00	343,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,469,657,923.41	3,503,144,353.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,469,657,923.41	3,503,144,353.51
39200	Биет хөрөнгө	3,297,904,983.41	3,331,664,753.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,731,834.00	1,246,731,834.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-96,594,257.52	-136,037,310.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	27,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-13,000,000.00	-9,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	52,772,134.00	68,572,134.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,954,771.56	-36,392,535.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,143,366.00	37,143,366.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,243,752.68	-21,227,861.02
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,016,104,410.00	2,018,719,410.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,097,911.41	153,318,209.41
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,151,890.24	-17,162,493.68
39300	Биет бус хөрөнгө	171,752,940.00	171,479,600.04
39301	Программ хангамж	833,340.00	833,340.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-360,000.00	-633,339.96
39303	Бусад биет бус хөрөнгө	171,279,600.00	171,279,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,507,999,043.41	3,556,367,486.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,507,999,043.41	3,556,367,486.51
51	Засгийн газрын хувь оролцоо	3,507,999,043.41	3,556,367,486.51
51100	Засгийн газрын оруулсан капитал	565,461,267.00	565,461,267.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	565,461,267.00	565,461,267.00
51200	Хуримтлагдсан үр дүн	125,330,409.36	173,698,852.46
51210	Өмнөх үеийн үр дүн	80,398,707.15	-3,382,668,634.05
51220	Тайлант үеийн үр дүн	44,931,702.21	3,556,367,486.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,817,207,367.05	2,817,207,367.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,507,999,043.41	3,556,367,486.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	309,224,861.78	3,866,328,396.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,673,863.00	3,608,834,341.41
120	Нийтлэг татварын бус орлого	99,673,863.00	3,608,834,341.41
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	99,473,863.00	3,570,493,221.41
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	200,000.00	38,341,120.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	209,550,998.78	257,494,055.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	195,221,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	195,221,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,597,500.00	18,801,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,597,500.00	13,801,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	206,953,498.78	43,471,455.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	206,953,498.78	43,471,455.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	263,903,408.80	300,100,146.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	263,903,408.80	300,100,146.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,393,408.80	296,600,146.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,780,650.01	134,338,019.00
210101	Үндсэн цалин	101,089,338.53	98,282,895.20
210102	Нэмэгдэл	24,479,311.48	21,723,151.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,212,000.00	6,247,000.00
210104	Урамшуулал	0.00	8,084,972.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,295,140.77	16,234,185.00
210201	Тэтгэврийн даатгал	11,636,985.39	11,599,748.95
210202	Тэтгэмжийн даатгал	1,294,316.69	1,368,580.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,035,453.40	1,091,504.20
210204	Ажилгүйдлийн даатгал	200,343.75	187,205.74
210205	Эрүүл мэндийн даатгал	2,128,041.54	1,987,145.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,499,200.00	23,422,848.00
210301	Гэрэл, цахилгаан	1,836,866.00	2,127,435.00
210302	Түлш, халаалт	24,004,619.00	20,249,753.00
210303	Цэвэр, бохир ус	657,715.00	1,045,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,277,880.00	20,155,020.00
210401	Бичиг хэрэг	2,083,760.00	3,451,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,160,800.00	1,710,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	905,600.00	908,380.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,400,320.00	2,908,620.00
210408	Бараа материал акталсны зардал	9,777,400.00	11,176,620.00
2105	Нормативт зардал	1,425,200.00	853,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,425,200.00	853,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,766,700.00	13,750,725.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	210,000.00
210604	Урсгал засвар	8,516,700.00	13,540,725.00
2107	Томилолт, зочны зардал	184,300.00	1,691,600.00
210702	Дотоод албан томилолт	184,300.00	1,691,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,232,508.00	12,865,945.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,232,508.00	12,865,945.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,931,830.02	73,288,104.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,931,830.02	73,288,104.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,510,000.00	3,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,510,000.00	3,500,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,510,000.00	3,500,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	45,321,452.98	3,556,367,486.51
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	389,750.77	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	389,750.77	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	44,931,702.21	3,556,367,486.51

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	209,550,998.78	257,494,055.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	13,801,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	13,801,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	13,801,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	13,801,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	209,550,998.78	243,692,555.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	195,221,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	195,221,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,597,500.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,597,500.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	206,953,498.78	43,471,455.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	206,953,498.78	43,471,455.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	209,550,998.78	227,350,322.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	209,550,998.78	227,350,322.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	207,040,998.78	223,850,322.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,780,649.99	134,338,019.00
210101	Үндсэн цалин	95,028,802.60	98,282,895.20
210102	Нэмэгдэл	29,399,847.39	21,723,151.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,352,000.00	6,247,000.00
210104	Урамшуулал	0.00	8,084,972.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,295,140.79	16,234,185.00
210201	Тэтгэврийн даатгал	11,636,985.39	11,599,748.95
210202	Тэтгэмжийн даатгал	1,294,316.69	1,368,580.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,035,453.40	1,091,504.20
210204	Ажилгүйдлийн даатгал	200,343.75	187,205.74
210205	Эрүүл мэндийн даатгал	2,128,041.56	1,987,145.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,499,200.00	23,422,848.00
210301	Гэрэл, цахилгаан	1,836,866.00	2,127,435.00
210302	Түлш, халаалт	24,004,619.00	20,249,753.00
210303	Цэвэр, бохир ус	657,715.00	1,045,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,261,800.00	9,129,300.00
210401	Бичиг хэрэг	2,603,980.00	1,771,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,160,800.00	1,710,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	905,600.00	908,380.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,641,420.00	4,739,420.00
2105	Нормативт зардал	1,425,200.00	1,545,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,425,200.00	1,545,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,249,900.00	14,448,725.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	908,000.00
210604	Урсгал засвар	8,999,900.00	13,540,725.00
2107	Томилолт, зочны зардал	184,300.00	1,691,600.00
210702	Дотоод албан томилолт	184,300.00	1,691,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,344,808.00	22,495,945.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,344,808.00	22,495,945.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	544,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	544,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,510,000.00	3,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,510,000.00	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,510,000.00	3,500,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	30,143,733.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	15,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	15,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	15,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	15,800,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-15,800,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	14,343,733.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	14,343,733.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	80,398,707.15	3,463,067,341.20
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	565,461,267.00	2,817,207,367.05	80,398,707.15	3,463,067,341.20
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	565,461,267.00	2,817,207,367.05	80,398,707.15	3,463,067,341.20
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	44,931,702.21	44,931,702.21
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	125,330,409.36	3,507,999,043.41
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-3,507,999,043.41	-3,507,999,043.41

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	-3,382,668,634.05	-3,382,668,634.05
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,556,367,486.51	3,556,367,486.51
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	173,698,852.46	3,556,367,486.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,961,100.00	238,150,322.00	-23,810,678.00	90.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,961,100.00	238,150,322.00	-23,810,778.00	90.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,193,100.00	234,650,322.00	-23,542,778.00	90.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,253,600.00	134,338,019.00	-7,915,581.00	94.44
210101	Үндсэн цалин	102,649,700.00	98,282,895.20	-4,366,804.80	95.75
210102	Нэмэгдэл	27,825,600.00	21,723,151.00	-6,102,449.00	78.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,166,000.00	6,247,000.00	-919,000.00	87.18
210104	Урамшуулал	4,612,300.00	8,084,972.80	3,472,672.80	175.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,707,800.00	16,234,185.00	-1,473,615.00	91.68
210201	Тэтгэврийн даатгал	11,811,600.00	11,599,748.95	-211,851.05	98.21
210202	Тэтгэмжийн даатгал	1,492,600.00	1,368,580.19	-124,019.81	91.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,194,000.00	1,091,504.20	-102,495.80	91.42
210204	Ажилгүйдлийн даатгал	298,600.00	187,205.74	-111,394.26	62.69
210205	Эрүүл мэндийн даатгал	2,911,000.00	1,987,145.92	-923,854.08	68.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,960,200.00	23,422,848.00	-8,537,352.00	73.29
210301	Гэрэл, цахилгаан	5,432,600.00	2,127,435.00	-3,305,165.00	39.16
210302	Түлш, халаалт	25,000,000.00	20,249,753.00	-4,750,247.00	81.00
210303	Цэвэр, бохир ус	1,527,600.00	1,045,660.00	-481,940.00	68.45
2104	Хангамж, бараа материалын зардал	8,049,300.00	8,049,300.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	948,000.00	1,771,500.00	823,500.00	186.87
210402	Тээвэр, шатахуун	546,300.00	630,000.00	83,700.00	115.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	908,380.00	68,380.00	108.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,400,000.00	0.00	-1,400,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,315,000.00	4,739,420.00	424,420.00	109.84
2105	Нормативт зардал	1,425,200.00	1,425,200.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,425,200.00	1,425,200.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,300,000.00	28,233,725.00	-1,066,275.00	96.36
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,800,000.00	15,800,000.00	0.00	100.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	908,000.00	-592,000.00	60.53
210604	Урсгал засвар	12,000,000.00	11,525,725.00	-474,275.00	96.05
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	406,600.00	-93,400.00	81.32
210702	Дотоод албан томилолт	500,000.00	406,600.00	-93,400.00	81.32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,997,000.00	21,995,945.00	-1,055.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,997,000.00	21,995,945.00	-1,055.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	544,500.00	-4,455,500.00	10.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	544,500.00	-4,455,500.00	10.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,768,000.00	3,500,000.00	-268,000.00	92.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,768,000.00	3,500,000.00	-268,000.00	92.89
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,768,000.00	3,500,000.00	-268,000.00	92.89
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	275,761,000.00	252,494,055.00	-23,266,945.00	91.56
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	195,221,100.00	195,221,100.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	195,221,100.00	195,221,100.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,940,000.00	43,471,455.00	-9,468,545.00	82.11
320001	Орон нутгийн төсвөөс	52,940,000.00	43,471,455.00	-9,468,545.00	82.11
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,800,000.00	13,801,500.00	1,500.00	100.01
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,800,000.00	13,801,500.00	1,500.00	100.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	14,343,733.00	14,343,733.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	29.00	29.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	14.00	14.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	14.00	14.00	0.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	8.00	8.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00	0.00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музей /Нэгдсэн музей/ нь “Ардын хувьсгалын түүхэн эд өлгийн зүйлсийг хадгалан хамгаалах, судлан таниулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Музей, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Нэгдсэн музейн санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Мөн Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн музейн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын онцлогт тохироогүй байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн музейн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,229.2 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	14,343.7	14,343.7
Бараа материал	38,341.1	38,879.4	538.3
Үндсэн хөрөнгө	3,469,657.9	3,513,005.1	43,347.2
Нийт хөрөнгө	3,507,999.0	3,566,228.2	58,229.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,507,999.0	3,566,228.2	58,229.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,507,999.0	3,566,228.2	58,229.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 14,343.7 мянган төгрөг болж өссөн нь урсгал дансны гүйцэтгэлээр санхүүждэг болсноос шалтгаалан төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 38,879.4 мянган төгрөг болж 538.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 34,986.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 23,289.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, 11,158.6 мянган төгрөгийн бараа материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 3,723,597.9 мянган төгрөг болж 103,635.3 мянган төгрөгөөр өссөн нь 15,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 2,615.0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгал хандиваар хүлээн авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 98,220.3 мянган төгрөгийн музейн гадна хашааг хүлээн авсан болон 13,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,566,228.2 мянган төгрөг болж 58,229.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 211,963.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 101,574.1 мянган төгрөг, нийт зарлагыг 313,537.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 4,099.4 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 512.6 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 68.1 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 0.2 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 17,696.9 мянган төгрөгөөр зэрэг **22,377.2** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 69,613.9 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 8,700.0 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 494.0 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 16,736.1 мянган төгрөгөөр зэрэг **95,544.0** мянган төгрөгөөр бууруулж, нийт **240,370.3** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 21,590.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн */Хангамж, бараа материалын зардлыг 875.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 17,800.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 180.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр г.м/* төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 195,221.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 52,940.0 мянган

төгрөгийг орон нутгийн төсвөөс, 13,800.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 195,221.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 43,471.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 13,801.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 238,150.3 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 7,915.6 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	184,453.1	170,378.9	14,074.2	92.4
2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,000.0	10,000.0	100.0	100.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	768.0	500.0	268.0	65.1
4	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	13,800.0	13,800.0	0.0	100.0
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	41,960.2	32,948.6	9,011.6	78.5
6	Нийтлэг үйлчилгээ	10,979.8	10,522.9	456.9	95.8
	Дүн	261,961.1	238,150.4	23,810.7	90.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Нэгдсэн музейн нэмэлт санхүүжилтийн 100130035402 тоот дансанд дээд шатны төсвийн захирагчаас 5,000.0 мянган төгрөг төвлөрч, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нэгдсэн музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн музейн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 263,903.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **2,639.0** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нэгдсэн музей нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэсэн,
- Сумдын орон нутгийн судлах танхимаар 1 удаа очихоор төлөвлөсөн боловч хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан цахимаар үйл ажиллагаатай танилцаж заавар зөвлөгөө өгч ажилласан,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8,537.3 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нэгдсэн музей нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 1 удаа,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 1 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 1 удаа,
- Байгууллагын батлагдсан төсвийг 1 удаа
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг 2 удаа
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 1 удаа,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 1 удаа
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 1 удаа,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг 1 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 1 удаа,
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны тайланг 1 удаа.

Шийдвэрлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас гэрээт ажилтны цалинд зарцуулсан 1,607.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, үндсэн хөрөнгө, багаж, тоног төхөөрөмж худалдан авахад бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас санхүүжүүлсэн 5,472.0 мянган төгрөгийн, албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”- аар баталгаажуулж, бүртгээгүй зөрчилд тус тус зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн боловч 12,148.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй, шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 2 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,607.4	1	1,607.4	100.0
Зөвлөмж	4	17,602.4	2	5,472.0	50.0
Нийт дүн	5	19,209.8	3	7,079.4	60.0

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй, шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагч, холбогдох байгууллагуудын шийдвэр, өгсөн чиглэлээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна.

Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт шилжүүлсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр эх үүсвэр хэлбэрээр төлөвлөж, зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.

2. Тус музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баярбаатар нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-д заасны дагуу тэтгэвэр тогтоолгох насанд хүрч төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөн өндөр насны тэтгэвэрт гарсан боловч аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар томилохдоо цалингийн хэмжээг ТҮСУ-6-3 шатлалаар, ур чадварын нэмэгдэл 25 хувь, орон нутгийн нэмэгдэл 15 хувь гэх мэт төрийн албан хаагчийн цалингийн сүлжээгээр тогтоосон байна. Иймээс захирлын ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлаж, захирлыг томилох, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэний цалинг төрийн албаны цалингийн сүлжээгээр бус гэрээний дагуу тогтоож олгох нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **2,597.5** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зарлагыг 2,597.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Аудитаар нийт 2,112.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 381.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,731.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Аймгийн Нийтийн номын сан, нэгдсэн музейн нягтлан бодогч П.Ууганбилэгт аймгийн Засаг даргын 2022 оны Б/29 дүгээр захирамжаар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг, хууль журам стандартын дагуу бэлтгэж аудитын тайлангаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэх үндэслэлээр албан тушаалын цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр урамшуулал олгох шийдвэрлэсэн байна. П.Ууганбилэгт аймгийн Нийтийн номын сангаас үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшуулал олгосон боловч Нэгдсэн музейн төсвөөс **381.2** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **1,731.5** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зарлагыг зөрүүтэй тайлагнасан	1	2,597.5			1	2,597.5	1	2,597.5				
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Урамшуулал давхардуулан олгосон	1	381.2	1	381.2									
Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан	1	1,731.5			1	1,731.5							
Дүн	2	2,112.7	1	381.2	1	1,731.5							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	14				14			
Огт мэдээлээгүй								
Дүн	14				14			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	14				14			